



МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2012 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А-21

Улаанбаатар хот

Журам, заавар батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг ачуулах, бүртгэх, кассын үйл ажиллагааны заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Энэ журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Валлот, эдийн засгийн газар (Д.Дэлгэрсайхан), Мөнгөний бодлого, судалгааны газар (Д.Болдбаатар), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-г тус тус үүрэг болгосугай.
4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Г.Тогтохбаатар)-г даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ




Л.ПҮРЭВДОРЖ

14 0192

Tushaal2012.doc

## ГЭМТЭЛТЭЙ ГАДААДЫН МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ СОЛИХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл



- 1.1. Энэ журмын зорилго нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу хүчинтэй боловч гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг банк<sup>1</sup> хүлээж авах, солихтой холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журмын 1.5-д заасан гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг ижил төрлийн мөнгөн тэмдэгтээр холбогдох шимтгэлийг суутган солих (цаашид солих гэх) үйл ажиллагаанд Монголбанкны Валют, эдийн засгийн газар (цаашид ВЭЗГ гэх), Мөнгөний бодлого, судалгааны газар (цаашид МБСГ гэх), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх), банкууд, тэдгээрийн захирал, ажил хариуцсан эдийн засагч, нягтлан бодогч болон нярав нар дагаж мөрдөнө.
- 1.3. Энэ журмын 1.1-д заасан “гадаадын мөнгөн тэмдэгт” гэдэгт зөвхөн гадаадын цаасан дэвсгэртийг ойлгоно.
- 1.4. Дор дурьдсан шинж бүхий гадаадын мөнгөн тэмдэгтийг хүчингүйд тооцно:
  - 1.4.1. Тэмдэгтийн хоёрны нэг буюу түүнээс дээш хэсэг нь тасарч алга болсон;
  - 1.4.2. Олон хэсэг болон тасарч, тэдгээрийг эвлүүлэхэд нэг тэмдэгт мөн биш нь ялгагдахгүй болсон;
  - 1.4.3. Шалгагч машинд уншигдахгүй буюу хуурамч тэмдэгт байж болзошгүй;
  - 1.4.4. Тэмдэгтийн тоо, үсэг, зураг, хэмжээ, өнгө зэрэг нь бүхэлдээ өөрчлөгдсөн;
  - 1.4.5. Хоёр өөр тэмдэгтийн тасархай наагдсан, серийн дугаар зөрсөн.
- 1.5. Энэ журмын 1.4-т заасан шинж тэмдэг агуулаагүй бөгөөд дор дурьдсан шинж бүхий гадаадын мөнгөн тэмдэгтийг гэмтэлтэйд тооцно:
  - 1.5.1. Их хэмжээгээр хиртсэн, элэгдсэн, өнгө зүсээ алдсан;
  - 1.5.2. Тэмдэгтийн хоёрны нэгээс бага хэсэг нь гэмтсэн (урагдсан, тасарсан, цоорсон, тасарсныг эргүүлж наасан);
  - 1.5.3. Будаг, тос, бэх, бичээс болон бусад төрлийн бодис тогтсон;  
Галд шатаад гуравны хоёроос дээш хэсэг үлдсэн;
  - 1.5.4. Усанд норсон;
  - 1.5.5. Их хэмжээгээр үрчийж хумигдсан.
- 1.6. Банк нь энэ журмын 1.4, 1.5-д зааснаас бусад гадаадын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд авна.
- 1.7. Банк нь иргэн, хуулийн этгээдийн энэ журмын 1.5-д заасан мөнгөн тэмдэгтийг солиулах тухай хүсэлтийг энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу хүлээн авна.

<sup>1</sup> Банкны тухай хуулийн 3.1.1-д зааснаар “банк” гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг ойлгоно.

## **Хоёр.Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих үйл ажиллагаа**

- 2.1. Бэлэн валютын зузаатгал эрхэлдэг банк нь гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих үйл ажиллагааг өөрийн дотоод журмын дагуу явуулна.
- 2.2. Бэлэн валютын зузаатгал эрхэлдэггүй банк нь бэлэн валютын зузаатгал эрхэлдэг бусад банкаар дамжуулан банк хооронд байгуулсан ерөнхий гэрээний дагуу энэ журмын агуулгад нийцүүлэн явуулна.
- 2.3. Энэ журмын 2.2-т заасан банк нь Монголбанкаар дамжуулан гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих үйл ажиллагааг эрхэлж болно. Энэ тохиолдолд дараахь байдлаар гүйцэтгэнэ:
  - 2.3.1. Банк нь энэ журмын 1.5-д заасан гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солиулах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу Монголбанкинд хүргүүлж, Монголбанк нь тусгай дансанд орлогодоно;
  - 2.3.2. Монголбанкинд энэ журмын 2.3.1-д заасны дагуу хүргүүлсэн гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих эсэх эцсийн шийдвэрийг энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр Монголбанктэй гэрээ байгуулсан гадаадын харилцагч банк, шаардлагатай тохиолдолд тухайн мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргагч эрх бүхий байгууллага гаргана;
  - 2.3.3. Энэ журмын 2.3.2-т заасан үйл ажиллагааны хугацаа болон гадаадын харилцагч банкны шимтгэлийн хэмжээ нь тухайн мөнгөн тэмдэгтийн гэмтлийн байдал, аль орны мөнгөн тэмдэгт болох зэрэг хүчин зүйлээс хамаарна;
  - 2.3.4. Монголбанк нь зөвхөн дараахь мөнгөн тэмдэгтийг гадаадын харилцагч банкинд явуулах замаар солих үйл ажиллагааг эрхэлж болно:
    - 2.3.4.1. АНУ-ын доллар;
    - 2.3.4.2. Европын Холбооны евро;
    - 2.3.4.3. Японы иен;
    - 2.3.4.4. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын фунт стерлинг.
  - 2.3.5. Энэ журмын 2.3.2-т заасны дагуу солиулахаар явуулсан гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн хуурамч болох нь тогтоогдсон бол тухайн тэмдэгтийг солихгүй, буцаан олгохгүй;
  - 2.3.6. Энэ журмын 2.3.2-т заасны дагуу солиулахаар явуулсан гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг сольсон эсэх хариуг гадаадын харилцагч банк ирүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор Монголбанк тухайн банкинд мэдэгдэнэ;
  - 2.3.7. Монголбанк нь төлөгдөж ирсэн цэвэр дүнгээс 10 хувьтай тэнцэх шимтгэлийг суутган авна.

### **Гурав.Монголбанкны бүрэн эрх**

- 3.1. Монголбанк нь энэ журмын 2.3.2-т заасны дагуу солиулахаар явуулсан гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг гадаадын харилцагч банк солих эсэхэд баталгаа гаргахгүй;
- 3.2. Монголбанк нь энэ журмын 2.3.2-т заасан үйл ажиллагааг тогтоосон хугацааны дотор гүйцэтгэх үүрэг хүлээхгүй.

## Дөрөв.Банкны эрх, үүрэг

4.1. Банк нь дор дурьдсан эрхтэй:

- 4.1.1. Энэ журмын 1.5-д заасан гэмтэлтэй мөнгөн тэмдэгтийг сольсон тохиолдолд өөрийн дотоод журмын дагуу харилцагчаас шимтгэл авах;
- 4.1.2. Энэ журмын 1.4-т заасан шинж тэмдэг бүхий гадаадын мөнгөн тэмдэгтийг солихоос татгалзах.

4.2. Банк нь дор дурьдсан үүрэгтэй:

- 4.2.1. Хуурамч мөнгөн тэмдэгт илрүүлэх тусгай тоног төхөөрөмжтэй байх;
- 4.2.2. Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг тоолж шалган, энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу хүлээж авах;
- 4.2.3. Хуурамч байж болзошгүй мөнгөн тэмдэгт илэрвэл хуулийн байгууллагад шалгуулах арга хэмжээ авах;
- 4.2.4. Энэ журмын 1.4, 1.5-д заасан мөнгөн тэмдэгтийн талаар анхааруулсан бичгийг харилцагчдад ил харагдах газар байрлуулж, тэдэнд тайлбарлах.

## Тав.Хариуцлага

5.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Банк санамсаргүй болон санаатайгаар хүчингүй эсвэл хуурамч мөнгөн тэмдэгтийг авсан тохиолдолд тухайн банк хариуцна.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам"-ын нэгдүгээр хавсралт -  
 ..... оны .....-р сарын .....-ны өдөр

УХИ0014

Банкны нэр .....

Салбарын код	Теллерийн		Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн				Харилцагчийн		
	Дугаар	Овог, нэр	Төрөл	Нэрлэсэн дүн	Серийн дугаар	Овог, нэр	Дансны дугаар	Оршин суугаа хаяг, холбоо барих утас	

Гэмтлийн байдлыг тодорхой бичих: .....

Гэмтэл хэзээ, хэрхэн үүссэн тухай бичих: .....

Санамж: Харилцагчийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргах!

Хүлээлгэн өгсөн:

.....Овогтой..... гарын үсэг / .....

Хүлээн авсан:

.....Овогтой..... гарын үсэг / .....

цаг..... МИНУТ .....

“Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг  
солих журам”-ын хоёрдугаар хавсралт

..... оны.....-р сарын.....-ны өдөр

Тушаагч банкны нэр .....

Дугаар .....



**Монголбанкинд хүргүүлсэн гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн жагсаалт**

Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн			
Төрөл	Нэрлэсэн дүн	Серийн дугаар	Гэмтлийн байдал
USD			
USD			
USD			
<b>USD нийт</b>	(.....)		
JPY			
JPY			
<b>JPY нийт</b>	(.....)		
EUR			
EUR			
<b>EUR нийт</b>	(.....)		
GBP			
GBP			
<b>GBP нийт</b>	(.....)		

Бүгд.....ширхэг ..... мөнгөн тэмдэгтийг  
хүргүүлэв.

/тамга, тэмдэг/ Хүлээлгэн өгсөн: ...../овог, нэр/  
Банкны Захирал: ...../овог, нэр/  
Нягтлан бодогч: ...../овог, нэр/  
Нярав: ...../овог, нэр/  
Хүргэсэн: ...../овог, нэр/

Монголбанкинд хүлээн авсан: ..... он ..... сар..... өдөр ..... цаг .....минут

Хүлээн авсан: МБСГ-ын Мөнгөн тэмдэгтийн хэлтсийн нярав .....овогтой.....  
/...../  
Гарын үсэг

## ГЭМТЭЛТЭЙ ГАДААДЫН МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ АЧУУЛАХ, БҮРТГЭХ, КАССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

### Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү зааврын зорилго нь “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам”-ыг хэрэгжүүлэхэд Төв банк (Монголбанк)-ны холбогдох газар, хэлтэс, нэгжийн үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2. Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг ачуулах, бүртгэх, кассын үйл ажиллагааг дараахь газар, хэлтэс, нэгж Монголбанкийг төлөөлж хийнэ:
  - 1.2.1. Валют, эдийн засгийн газар /цаашид “ВЭЗГ” гэх/;
  - 1.2.2. Мөнгөний бодлого, судалгааны газар /цаашид “МБСГ” гэх/;
  - 1.2.3. Төлбөр тооцоо, бүртгэлийн газар /цаашид “ТТБГ” гэх/.

### Хоёр.Ерөнхий зарчим

- 2.1. МБСГ-ын Мөнгөн тэмдэгтийн хэлтэс нь гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгт солиулах саналыг ажлын өдрийн 16:00 цаг хүртэл “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам”-ын 2.3.1-т заасны дагуу хүлээн авна.
- 2.2. ТТБГ-ын Бүртгэлийн хэлтэс нь энэ зааврын 2.1-д заасны дагуу ирүүлсэн гэмтэлтэй мөнгөн тэмдэгтийн бүртгэлийг хөтөлнө.
- 2.3. ВЭЗГ-ын Санхүүгийн зах зээлийн хэлтэс нь гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг гадаадын харилцагч банкинд хүргүүлэх, солиулах үйл ажиллагааг хариуцна.
- 2.4. Гэмтэлтэй мөнгөн тэмдэгтийн төлбөр тооцооны талаар гадаадын харилцагч банкнаас ирүүлсэн SWIFT баримтыг үндэслэн “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам”-ын 2.3.6-д заасны дагуу ТТБГ-ын Бүртгэлийн хэлтэс холбогдох гүйлгээг хийн тухайн банкинд мэдэгдэнэ.

### Гурав.Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн кассын ажиллагаа

- 3.1. Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн кассын ажиллагааг МБСГ-ын Мөнгөн тэмдэгтийн хэлтсийн нярав, нягтлан бодогч нар хариуцаж, дараахь байдлаар гүйцэтгэнэ:
  - 3.1.1 Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн орлогын гүйлгээг Монголбанкнаас баталсан “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам”-ын хоёрдугаар хавсралтыг үндэслэн хийнэ.
  - 3.1.2 Нягтлан бодогч банкнаас орлогын баримтыг хүлээн авч, бичилтийг шалгасны дараа холбогдох дансаар нь гүйлгээг хийж, гарын үсэг зурж, нягтлан бодогчийн тэмдэг дарж, баримтыг няравт шилжүүлнэ.
  - 3.1.3 Нярав банкны тушааж буй гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг ангилж, нэг бүрчлэн шалгаж хүлээн авсны дараа орлогын баримтад гарын үсэг зурж, кассын тэмдэг дарна. Энэхүү баримтын нэг хувийг банкинд өгнө.

- 3.1.4 Кассын орлогын баримтад гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн загварыг Монголбанкны Ерөнхийлөгч батална. Гарын үсэг зурах эрх бүхий этгээд өөрчлөгдмөгц түүний гарын үсгийн загварыг хүчингүйд тооцно. Батлагдсан гарын үсгийн хэв загварыг нягтлан бодогч хадгална.
- 3.1.5 Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг тоолж шалгах, боох ажиллагааг банкны ажилтны дэргэд “Монголбанкны бэлэн мөнгө хүлээн авах, тоолох, хянах заавар”-ын дагуу ажил үүргийн хуваарийг нь тодорхой заасан тоологч, мөнгө боогч нярав нар гүйцэтгэнэ.
- 3.1.6 Нярав нь “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам”-ын 1.4-т заасан хүчингүй гадаадын мөнгөн тэмдэгтийг хүлээн авахгүй.
- 3.1.7 Нярав гэмтэлтэй гадаадын дэвсгэрт тус бүрээр нь ялгаж ширхэглэн тоолж, дугтуйд хийж нүүрэн талд нь огноо, хүлээн авсан хүний дардас тэмдэг дарна.
- 3.1.8 Нярав гэмтэлтэй гадаадын дэвсгэртийг гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн тусгай дансанд байршуулан, дараагийн гадаад бэлэн валютын зузаатгалыг ачих хүртэл хадгална.
- 3.1.9 Нярав “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам”-ын хоёрдугаар хавсралтын хуулбарыг нөөцийн мэргэжилтэнд 7 хоног бүрийн Даваа гарагийн өглөө хүргүүлэн гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн тоо хэмжээг мэдэгдэнэ.

**Дөрөв.Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг ачуулах,  
солиулах үйл ажиллагаа**

- 4.1. “Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгт солих журам”-ын 2.3.2-т заасан гадаадын харилцагч банкинд Монголбанкны гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг ачуулах, солиулах үйл ажиллагааг ВЭЗГ-ын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн нөөцийн мэргэжилтэн /цаашид “нөөцийн мэргэжилтэн” гэх/ хариуцаж, дараахь байдлаар гүйцэтгэнэ:
  - 4.1.1. Нөөцийн мэргэжилтэн нь энэ зааврын 3.1.9-т заасны дагуу мэдэгдсэн гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг гадаад бэлэн валютын зузаатгалын захиалгатай хамт гадаадын харилцагч банкинд Ройтерс дилинг болон утсаар мэдэгдэж гэмтэлтэй мөнгөн тэмдэгтийг ачуулах захиалгыг өгнө.
  - 4.1.2. Гадаад бэлэн валютын зузаатгал хийх өдөр тодорхой болмогц нөөцийн мэргэжилтэн нь гэмтэлтэй мөнгөн дэвсгэртийн төрөл, тоо ширхэг, үнийн дүн, гадаадын банк санхүүгийн байгууллага дахь Монголбанкны харилцах дансны дугаарыг гадаадын харилцагч банктай Ройтерс дилингээр солилцож, зохих хэлцлийг “Гадаад арилжааны үйл ажиллагаа явуулах заавар”-ын дагуу хийнэ.
  - 4.1.3. Гадаад бэлэн валютын зузаатгалын хэлцэл хийгдсэний дараа нөөцийн мэргэжилтэн нь хэлцлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэл сангийн няравт мэдэгдэнэ. Нярав нь гэмтэлтэй гадаадын мөнгөн дэвсгэртийг тусгайлан тэмдэглэсэн боодол баглаа бүхий уутанд хийж бэлэн валютын зузаатгалд явуулах мөнгөн тэмдэгтийн хамт Монголбанкны итгэмжлэгдсэн төлөөлөгчид хүлээлгэн өгөхөд бэлдэнэ.
  - 4.1.4. Бэлэн валютын зузаатгалтай хамт явуулсан гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг гадаадын харилцагч банк хүлээн авч, сольсон эсэх талаархи мэдээллийг холбогдох баримтын хамт факс болон цахим шуудангаар нөөцийн мэргэжилтэн хүлээн авч, ТТБГ-ын Бүртгэлийн хэлтсийн гадаад гүйлгээ хариуцсан нягтлан бодогчид мэдэгдэнэ.

**Тав.Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн  
бүртгэлийн үйл ажиллагаа**

ТТБГ-ын Бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч нь Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийн бүртгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

**Зургаа.Хариуцлага**

Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_